



ХҮН НАМ

Дүүргийн ИТХ-ын сонгууль 2024

**СУДАЛГААНД
СУУРИЛЖ
ДҮҮРГЭЭ
ХӨГЖҮҮЛЬЕ**

**ХАН-УУЛ ДҮҮРЭГ 13-Р ТОЙРОГ
20-Р ХОРОО**

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛД ХҮН НАМААС НЭР ДЭВШИГЧ

БАТЖАРГАЛЫН

БИЛЭГТСАЙХАН



БАТЖАРГАЛЫН БИЛЭГТСАЙХАН

Батжаргалын Билэгтсайхан нь 1985 оны 10 сарын 31-нд
Сэлэнгэ аймагт төрсөн. ХҮД-ийн 20-р хорооны иргэн.

БОЛОВСРОЛ:

- 2018 он Тайваны Southern Taiwan University of Science and Technology сургуулийн Бизнесийн удирдлагын докторын (Ph.D) хөтөлбөр
- 2015 он Хүмүүнлэгийн ухааны их сургуульд бизнесийн удирдлагын магистр
- 2007 он Санхүү эдийн засгийн их сургуулийг Бизнесийн эдийн засагч мэргэжлээр
- 2003 он Нийслэлийн Буян-Ухаа Ерөнхий боловсролын сургууль

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 2012 оноос “Эм Ай Си Жи” ХХК-ийн гүйцэтгэх захирал
- 2020-2022 он “Тээвэр хөгжлийн банк” ахлах менежер
- 2018-2020 он “Говь” ХК-д Стратеги төлөвлөлт, бизнес шинжилгээний албаны дарга
- 2016-2017 он “Барилга мн” ХХК-ийн судалгааны албаны дарга
- 2007-2009 он “Хадгаламж банк”-нд Эрсдэлийн эдийн засагч

ХЭВЛҮҮЛСЭН БҮТЭЭЛ:

2016 онд барилга үл хөдлөх
хөрөнгийн судалгааны тайланг
гаргасан.



ХҮН НАМ



Сонгогч танг ингээх захидал

Сайн байна уу? Намайг Батжаргалын Билэгтсайхан гэдэг. Эдийн засагч мэргэжилтэй, судалгаа зөвлөх үйлчилгээний салбарт 10 гаруй жил ажилласан туршлагатай. Энэ хугацаанд эдийн засаг, бизнес, нийгмийн олон судалгааны ажил, төслүүдийг хийж гүйцэтгэлээ.

Улаабаатар хот, дүүргийн асуудлыг судалгаагаар тодорхойлж, шийдвэрлэх боломжуудыг тодорхойлж ажилласан. Тиймээс би өөрийн мэдлэг боловсрол, ажлын туршлагадаа тулгуурлан олон ажлыг хийхээр өөрийн амьдардаг Хан-Уул дүүргийн 20-р хороонд буюу Дүүргийн ИТХ-ын сонгуулийн 13-р тойрогт ХҮН намаас нэр дэвшээд байна. Манай хороонд олон барилга шинээр баригдаж, хүн амын нягтрал нэмэгдэхийн хэрээр явган хүний зам багасаж, машины орц гарц, түгжрэл, авто зогсоолын хүрэлцээ, хүүхдийн тоглоомын талбай дутмаг байдал зэрэг асуудлууд бий болж байгаа.

Бид одоо л засаж сайжруулахгүй бол буруу төлөвлөлт, тав тухгүй байдал нэмэгдсээр байна.

Хэрвээ би Дүүргийн ИТХ-д сонгогдвол аливаа ажлыг судалгаа, тооцоотой хийн, үр ашигтай хөрөнгө оруулалт хийж, иргэдийн оролцоотой хөгжлийг бий болгохыг зорьж ажиллах болно.

*Хүндэтгэсэн,
Батжаргалын БИЛЭГТСАЙХАН*



**ХҮН НАМЫН ЕНБД,
УИХ-ЫН ГИШҮҮН П.ГАНЗОРИГ**



**АВГА АХ, ДЭД ХУРАНДАА
Д.ГОМБОДОРЖ**



**НАГАЦ АХ, ГАЗАРЗҮЙН УХААНЫ
ДОКТОР (PH.D), ЗОХИОЛЧ,
ОРЧУУЛАГЧ Х.ХАНГ АЙСАЙХАН**

СУДЛААЧ ЗАЛУУЧУУДЫНХАА ХҮЧЭЭР ДҮҮРЭГ, ХОТОО ХӨГЖҮҮЛЬЕ.

Дүүргийн ИТХ иргэдийн амьдрах орчин, эдийн засаг, нийгэм, олон нийтийн асуудлаар чухал шийдвэрүүдийг гаргадаг. Нийслэл, дүүргийн түвшинд тооцоо, судалгаатай нарийн төлөвлөлт ихээр дутагдаж байгаа ийм үед мэргэшсэн судлаачдын оролцоог дэмжиж мэдлэг туршлагыг нь ашиглах хэрэгтэй байна. Батжаргалын Билэгтсайхан бол судалгааны салбарт танигдсан, чадварлаг мэргэжилтэн учраас Дүүргийн ИТХ-д нэр дэвшиж байгаад талархаж байна.

ЦЭРЭГ ЭХ ОРОНЧ УДАМТАЙ ХҮҮ

Бид Төв аймгийн Алтанбулаг сумын харьяат, эцэг эхээс арвуулаа. Миний тав дахь дүү маань Батжаргал юм. Батжаргал маань Цэргийн тусгай дунд сургууль төгссөн офицер хүн байсан. Сэлэнгэ аймгийн байцаан өнгөрүүлэх, Дорнод аймгийн Сүмбэр сумын Бурхантын заставт ажиллаж байсан, цэргийн хүн байлаа. Иймээс ч бага наснаасаа л цэргийн амьдралд ойр өссөн Батжаргалын Билэгтсайхан маань даруу төлөв, аливаа ажилд цуцдаггүй, цэргийн хүний дайчин чанарыг өвлөн авсан нь бахархууштай.

АЛИВАА АЖИЛ ХЭРЭГТ ТУЙЛБАРТАЙ ХАНДДАГ

Өвөө аав Г.Аниа нь Увс аймгийн Бөхмөрөн сумын уугуул. Миний аав Хүрэн-Алаг мужаан хүн байсан. Миний бие ЗХУ-д Байгалийн ухааны чиглэлээр дээд сургууль төгссөн, зохиолч, орчуулагч хүн юм. Билэгтсайхан нь мэргэжлийн өндөр чадвартай, англи хэл эзэмшсэн, аливаа ажил хэрэгт туйлбартай ханддагт нь ууган нагацын хувьд миний бие баяртай явдаг юм. Энэ утгаараа дүү маань Дүүргийн ИХТ-т нэр дэвшиж байгааг дэмжиж байна. Энэхүү чухал ажлыг үр бүтээлтэй, нэр төртэй хашиж чадна гэдэгт итгэж байна.

Холбоо барих:



9111-1511



Bilegtsaikhan batjargal



www.micg.mn/Bilegtsaikhan